



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар A/151

Арвайхээр

Г Уржлийн малд үзлэг ангилалт хийх,  
баталгаажуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.“а”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 2.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн санхүүжилтээр Баянгол сумын “Баянгол омог”-ийн 2500 хонь, Уянга сумын нутгийн 5000 сарлаг, Нарийнтээл сумын “Тээлийн улаан” нутгийн шилмэл хэвшлийн 2500 ямаа, Гучин-Ус сумын “Монголын хоолой”-н 2000 тэмээ, Есөнзүйл сумын нутгийн 3000 адуунд нийт 5 сумын 15000 толгой малд үзлэг, ангилалт хийх, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан болон удам зүйн үнэлгээний программд оруулах ажлыг 2020 оны 04 дүгээр сарын 15-наас 11 дүгээр сарын 15-н хүртэлх хугацаанд зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Тус сумдын үзлэг ангилалтад хамрагдсан малаас цөм сүрэг бүрдүүлэх, үүнээс хээлтүүлэгч бойжуулах, сайжруулагчаар ашиглах боломжийг судлан шийдвэрлэх, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан болон удам зүйн үнэлгээний программд оруулах ажлыг гүйцэтгэх мал үржүүлэг, технологийн нэгжийг сонгох, гэрээ байгуулах, төсөв, хөрөнгийн хуваарилалт, зарцуулалтад хяналт тавьж, тайланг нэгтгэн холбогдох газарт хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

3. Үзлэг ангилалтын ажлыг сум орон нутагтаа зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг дээрх сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011100335

Аймгийн Засаг даргын 2020 оны 04  
дугаар сарын 08-ны өдрийн 15 дугаар  
захирамжийн хавсралт

ҮРЖЛИЙН МАЛД ҮЗЛЭГ, АНГИЛАЛТ ХИЙХ, ХЭРЭГЖИЛТЭНД  
ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: С.Цэдэнбалжир -аймгийн Засаг даргын дэргэдэх  
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга  
Нарийн бичгийн дарга: Б.Цэнгэл -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс,  
хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга  
Гишүүд: С.Бат-Эрдэнэ -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж  
ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн  
Ж.Энхтуяа -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн  
газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн  
Т.Долгормаа- аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн  
газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн  
Баянгол, Гучин-Ус, Нарийнтээл, Уянга, Есөнзүйл сумын Засаг дарга  
нар  
Сумдын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн Мал аж  
ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт менежмент, малын үржил бүртгэлийн  
асуудал хариуцсан мэргэжилтэн

-оОо-